



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/21

Ханх сум

**Бүх нийтийн хог цэвэрлэгээ
зохион байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалын улирал эхэлсэнтэй холбогдуулан нутаг дэвсгэрийн хэмжээнд гэр хорооллын бүсийн гудамж талбай, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд болон автозамын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, малын сэг зэмийг халдваргүйжүүлэх устгах, нийтийн эзэмшлийн ногоон байгууламж бүхий талбай, сад, цэцэрлэгт хүрээлэнгийн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 15-наас 19-ний өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгуулж, тайлан мэдээг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлж ажиллахыг Засаг даргын орлогч бөгөөд Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (Б.Баттүвшин)-д даалгасугай.

2. Бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хог хаягдлыг цэвэрлэх ажлын удирдамжийг хоёрдугаар, хог цэвэрлэгээний нэгдсэн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Баасансүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Л.ДАВААБАЯР